

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12 Шилэн дансны мэдээлэл	9
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал .....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	24

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 116  
ДУГААР СУРГУУЛИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.ЧИНБААТАР ТАНАА

2020.02.27 № 06/633  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд санхүүгийн тайланг аудитын байгууллагад хүргүүлээгүй, аудитын явцад санхүүгийн баримт материалыг зохих хугацаанд гаргаж ирүүлээгүй ба аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархалттай байна. Үүнд:

- “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын дагуу бэлэн мөнгөний кассын тайланг бэлтгэж санхүүгийн байдлын тайланд тусгаагүй;
- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл байхгүй, үндсэн хөрөнгүүд нь код, дугааргүй байгаа нь үндсэн хөрөнгийн түүвэрчилсэн тооллого хийх боломжгүй;
- Бараа материалын тооллогын бүртгэл байхгүй, шаардах хуудсаар бараа материалыг зарлагадаагүй нь бараа материалын түүвэрчилсэн тооллого хийх, үлдэгдлийг нотлох боломжгүй;
- Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, аудитын тулган баталгаажуулалтаар өр төлбөрийн үлдэгдэл зөрүүтэй, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй;
- Цалин хөлсийг тооцохдоо захирлын тушаал шийдвэр, цагийн бүртгэлээс зөрүүтэй, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын суутгалуудын хувь хэмжээг буруу тооцсон;
- Сургуулийн спорт заал түрээслүүлсэн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй;
- Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 56 мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй;
- Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй;


Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байх, үнэлгээ, хэмжилт, толилуулага ба тодруулга болон иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүрэг гүйцэтгэгч Д.Чинбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын систем, санхүүгийн программыг боловсронгуй болгох, сайжруулах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, элэгдлээрээ анхны өртгөө хаасан, ашигладаггүй биет болон биет бус үндсэн хөрөнгүүдийг актлах, дахин үнэлэх арга хэмжээ авах, Боловсролын салбарын хүрээнд тохирсон НБББББ-ийг боловсруулж дагаж мөрдөх, бэлэн мөнгөний кассын ажиллагаа, хадгалалт хамгаалалтын хяналтыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Их Наяд Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Их наяд аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлж буй боловсролын үйлчилгээг чанаржуулж, суралцагчдыг бодит чадвартай иргэн болгон төлөвшүүлэх”-д оршино гэж тодорхойлсон байна.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн тусгай хэрэгцээт боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Багш ажилчдын цалинтай холбоотойгоор ажилласан жил, үндсэн цалин хөлс, зэрэглэл, албан тушаал, мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох зэргийг шинэчлэн баталсан;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;

#### **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Ерөнхий боловсролын 116 дугаар сургуульд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахриогер 3.52 программ хангамж ашигладаг байна.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөгүй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

#### **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн 0.5 хувиар тооцон 4,958.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлын 0.5 хувиар буюу 6,680.5 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийг өндөр гэж үнэлэн хүлээн зөвшөөрөх материаллаг түвшний хэмжээг багаар тодорхойлж үзсэнтэй холбоотой болно.

## 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,590.8 мянган төгрөгөөр буюу 6,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	97.0	-	-97.0
Урьдчилгаа	-	1,150.0	1,150.0
Бараа материал	118,058.7	129,619.1	11,560.4
Үндсэн хөрөнгө	2,693,069.4	2,981,069.1	287,999.7
Хуримтлагдсан элэгдэл	-636,395.3	-797,417.6	-161,022.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,174,829.9</b>	<b>2,314,420.7</b>	<b>139,590.8</b>
Өр төлбөр	1,197.9	10,667.7	9,469.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,173,632.0	2,303,753.0	130,121.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,174,829.9</b>	<b>2,314,420.7</b>	<b>139,590.8</b>

Тайлант онд 5 ажилтанд цалингийн урьдчилгаа олгосноос урьдчилгаа дансны үлдэгдэл 1,150.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 129,619.1 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өсч, тайлант оны эцэст нөөц үүсгэсэн нь БСШУЯ-аас 18,452.8 мянган төгрөгийн хандиваар авсан бараа материал нэмэгдсэнтэй холбоотой.

БСШУЯ-аас хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 285,337.2 мянган төгрөгийн 129 ширхэг биет хөрөнгө, 2,211.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө болох брайль программаар тус тус нэмэгдсэн нь тайлант онд үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,981,069.1 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар өсөхөд нөлөөлжээ.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,469.8 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдын цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын өр төлбөрийг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 130,121.0 мянган төгрөг буюу 6.0 хувиар өссөн нь тайлант жилд хандивын буюу үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нөлөөлсөн байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,166,282.0 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөснөөс,

гүйцэтгэлээр урсгал зардалд 1,166,117.6 мянган төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 16.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 37 эрсдэл тодорхойлж нийт 62 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,309,747.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5,188.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,893.4 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 61,020.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,241,645.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

Аудитын явцад ажилчдын тооцсон цалинг нягтлан бодох бүртгэлийн журналд бүртгэхдээ 3,028.5 мянган төгрөгөөр дутуу, жирэмсэн болон хүүхдээ асрах чөлөөтэй байгаа ажилчдын байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шийтгэл 2,160.0 мянган төгрөгийг зардалд бүртгээгүй нийт 5,188.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залрууллаа.

Аудитаар дараах 1,304,559.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 62,913.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Сургуулийн спорт заалыг түрээслүүлсэн 1,395.0 мянган төгрөгийн бэлэн мөнгөний орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

2. Тооллогын бүртгэлээр цахилгаанчинд бүртгэлтэй 2 төрлийн 3 ширхэг нийт 498.4 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

3. Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтнуудад шүүхийн шийдвэрээр 17,287.7 мянган төгрөгийн нөхөн олговрыг төсвийн хөрөнгөөс олгосон нь Монгол Улсын Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн, 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Бараа материалын тооллогын бүртгэл байхгүй, 12,923.5 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар зарлагадаагүй, түүвэрчилсэн тооллого хийж үлдэгдлийг нотлох боломжгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар” –ын 6-д “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “оршин байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Харилцагч байгууллагуудад төлөх 14,311.3 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “оршин байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

6. Хүнсний материалын батлагдсан төсвөөс 2,101.3 мянган төгрөгийн шинэ жилийн бэлэг авч тараан, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

7. Цалин хөлсийг бодохдоо захирлын тушаал, шийдвэр, батлагдсан цагийн бүртгэлээс хоног, хувь нь илүү, дутуу нийт 14,396.5 мянган төгрөгийн зөрүүтэй бодсон зөрчил нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйл 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”, 49.6-д “Цагаар ажилласан ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагаар нь тооцож тухай бүр олгоно”, 50 дугаар зүйлийн 50.1-д “Ажилтанд үндсэн цалин дээр нь ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгож болно”, 50.2-т “Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “хэмжилт”, “үнэн зөв байдал” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

8. Тайлант хугацааны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр аудитын байгууллагад хүргүүлж 5 хоног хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-

ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

9. Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 56 мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

10. Өмнөх аудитын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх;” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 1,241,645.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар касс, үндсэн хөрөнгө, бараа материал, цалингийн бүртгэл, өр төлбөр, шилэн дансыг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

**2.12 Шилэн дансны мэдээлэл**

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 8 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 56 мэдээллийг байршуулаагүй байна.

**2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд аудитын байгууллагад хүргүүлэх зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй, 2019 оны тайлант жилд дахин хоцроосон.

Нийт 28,471.9 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 20 хувьтай буюу 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

**2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 1,304,559.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 6,680.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархалттай байгаа тул “Сөрөг” санал дүгнэлт өглөө.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн

тайланд үзүүлэх үр нөлөө, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. **Балансын данстай холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний кассын талаар:

- Сургуулийн спорт заал түрээслүүлсэн бэлэн мөнгөний орлого болон түүний зарцуулалтыг санхүүгийн тайланд тусгаагүй;
- "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөөгүй;
- Кассын бэлэн мөнгөний хадгалалт хамгаалалт болон хяналт сул;

##### 1.2. Эрсдэл:

- Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх;
- Бэлэн мөнгө дутагдах, шамшигдах;

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

- Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллах;
- Дотоод хяналтын системийг сайжруулж, ерөнхий нягтлан бодогч нь кассын үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, эрх үүргийнхээ хүрээнд хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч ажиллах;

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Заал түрээсийн орлогыг няравт тушаадаг, зарцуулалтыг нягтланд огт тайлагнадаггүй. Энэхүү заалын түрээсийн орлогын талаар миний бие мэдэхгүй тул спорт заалыг түрээслүүлсэн орлогыг ямар нэгэн бүртгэлд тусгадаггүй болно. Өөр орлого байхгүй.

Чөлөөт цагт спорт заалыг түрээсэлж болно гэж сургуулийн захирлын үүрэг даалгавраар өдөр бүрийн ээлжинд гарч буй жижүүрүүд түрээслээд, орлогыг няравт тушаадаг, зарцуулалтыг нягтланд огт тайлагнадаггүй. Заалнаас өөр орлого болон бэлэн мөнгө байхгүй.

#### 2 **Балансын данстай холбоотой асуудал**

##### 2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн талаар:

- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, эд хариуцагчийн карт нягтлан бодогчид байхгүй, хөрөнгүүд нь код дугааргүйгээс хөрөнгийн 741,773.3 мянган төгрөгийн түүвэрчилсэн тооллого хийх боломжгүй болсон;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 439,871.8 мянган төгрөгийн биет хөрөнгө, 13,655.8 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, нийт 453,527.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг актлах, дахин үнэлэх талаар арга хэмжээ аваагүй;

## 2.2 Эрсдэл:

- Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх, дутагдах;
- Үндсэн хөрөнгийн тооллогоор хөрөнгө давхардах, илүү, дутуу буруу тоологдох;
- Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дүнд ашиглахгүй, эвдэрч гэмтсэн, актлах болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн дүнгээр өсөж харагдах;

## 2.3 Өгсөн зөвлөмж:

- Үндсэн хөрөнгө тус бүрийг коджуулж дугаарлах, эд хариуцагчийн картанд код дугаараар тоо ширхэг, үнийн дүнгийн хамт бүртгэх;
- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, эд хариуцагчийн картын нэг хувийг санхүүгийн албанд хүргүүлэх;
- Эд хөрөнгийн тооллогын дүн, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн хөрөнгө актлаж данснаас хасах, дахин үнэлэх асуудлаа тухай бүрд нь Төрийн өмчийн хороонд хүргүүлж зохих шийдвэр гаргуулж байх;

## 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тооллогын бүртгэл, тооллогын илтгэх хуудас нягтлан бодогчид ирээгүй, нярав солигдож шаардлагатай материалуудыг гаргаж өгч чадаагүйгээс төрийн өмчийн хороонд актлах хүсэлтээ гаргаж өгөөгүй. 2020 ондоо гаргаж өгнө.

## 3. **Балансын данстай холбоотой асуудал**

### 3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн бүртгэлд ашиглаж байгаа 550.0 мянган төгрөгийн санхүүгийн программ нь нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг буруу тооцдог, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ба сайжруулж, шинэчлээгүй.

### 3.2 Эрсдэл:

- Санхүүгийн болон нийгмийн даатгал, татварын тайлан буруу илэрхийлэгдэх;
- Ажилчдын төлсөн татвар, шимтгэлүүд нь дутуу тооцогдож хохирох;

### 3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг сайжруулан, холбогдох хууль, стандарт, дүрэм, журмуудын өөрчлөлтийг тухай бүрд нь нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчилж байх.

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Санхүүгийн программын шинэчлэлтийг цаг тухайд нь хийлгэж сайжруулж ажиллана.

## 4. **Балансын данстай холбоотой асуудал**

### 4.1 Илрүүлэлт:

Харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй ба аудитын тулган баталгаажуулалтаар өр төлбөрийн үлдэгдэл 10,685.2 мянган төгрөгөөр зөрүүтэй.

4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

4.3 Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.3-т заасны дагуу бүх өр төлбөрийг заавал бүртгэж санхүүгийн тайлан балансад тусгах, 20.2.6-д заасны дагуу худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах;
- Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу авлага, өр төлбөр үүсгэхгүй талаар арга хэмжээ авч ажиллах;

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тооцоо нийлсэн актууд байгууллагуудаас авч бүрэн дуусаагүй байсан.

**5 Балансын данстай холбоотой асуудал**

5.1 Илрүүлэлт:

Нийт 16 байгууллагаас худалдан авалт хийснээс 5 байгууллагатай гэрээ хийсэн ба бусад харилцагч байгууллагуудтай 27,012.2 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээ хийгдээгүй, үнийн харьцуулалт байхгүй, шууд худалдан авалт хийсэн.

5.2 Эрсдэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчигдөх.

5.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг гэрээ болон төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх.

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Гэрээ бол хийгдсэн, аудит дээр ирээгүй гэрээнүүд няравт байгаа. Үнийн харьцуулалтыг баримтжуулж хийгээгүй. Зарим нэг гэрээ нь 1-2 жилийн хугацаатай байгуулагдсан. Өндөр дүнтэй худалдан авалт хийгддэггүй учраас зарим байгууллагатай гэрээ байгуулаагүй.

**6. Зардлын данстай холбоотой асуудал**

6.1 Илрүүлэлт:

Цалинтай холбоотой:

- Цалингаас хувь хүний орлогын албан татварыг суутгахдаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх шатлалыг буруу тооцож дутуу 518.6 мянга, илүү 346.1 мянга, нийт 867.4 мянган төгрөгийн зөрүүтэй суутгасан;
- Ажилчдын цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг татварын тайланд 1,052.4 мянган төгрөгийн зөрүүтэй дутуу тайлагнасан;
- Цалингийн хүснэгтээс Нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа ажилчдын цалинг дутуу 933.4 мянга, илүү 1,760.4 мянга, нийт 2,693.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Ажилтны цалингаас даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг суутгахдаа 1,3,5,8 саруудад нийт 268.6 мянган төгрөгийг дутуу суутгасан;
- Ажилтны нэр андуурагдан үндсэн цалинг 70.8 мянган төгрөгөөр дутуу бодсон;
- 2018 оны өмнөх даргын тушаалаар ажилчдын шагнал урамшуулал 860.0 мянган төгрөгийг санхүүгийн тайлант жилд олгоогүй, 2019 онд олгосон;
- Шүүхийн шийдвэрээр нийт 11 ажилтанд олгох нөхөн олговроос ажилгүй байсан хугацааны 2,287.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож, Нийгмийн даатгалын байгууллагад нөхөн тайлагнаагүй;

6.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;
- Нийгмийн даатгалын шимтгэл, Хувь хүний орлогын албан татварын тайлан буруу дүнгээр тайлагнагдах;
- Ажилтан дутуу цалин авч хохирох;

**6.3 Өгсөн зөвлөмж:**

- Санхүүгийн программыг шинэчлэгдсэн хууль, тогтоомжийн өөрчлөлтийг тусган сайжруулах, цалингаас суутгах нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу суутгаж, тайлагнах;
- Ажилчдын цалинг бодохдоо овог нэр, албан тушаал зэрэг ажилтны мэдээллийг сайтар хянаж цалинг бодож байх;
- Төсөв захирагчийн болон шүүхийн шийдвэрийн тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь биелүүлж ажиллах;
- Нийгмийн даатгалын нөхөн тайлан гаргаж, ажилчдын дэвтэрт бичилт хийн баталгаажуулах;

**6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар**

Цалингаас суутгадаг бүх татваруудыг гараар хувийг нь өөрчилж оруулах боломж байдаггүй тул программын алдаа гарсан байсныг нь нягталж үзээгүй байх гэж үзэж байна. Нягтлан бодогч хоногийг нягталж үзэлгүй илүү оруулсан.

**7. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

**7.1 Илрүүлэлт:**

Санхүү, нягтлан бодох бүртгэлд даган мөрддөг, ашигладаг “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байхгүй.

**7.2 Эрсдэл:**

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа УСНББОУС болон байгууллагын онцлог, салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой уялдахгүй байх.

**7.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2.-т заасны дагуу өөрийн байгууллагын онцлог, Боловсролын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” -ийг боловсруулж батлан, мөрдөж ажиллах.

**7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

2010 онд батлагдсан НБББББ бүртгэлтэй байдаг ч баталгаажуулсан тушаал байдаггүй. 2019 онд шинэчилж хийлгэсэн одоогоор баталгаажуулаагүй байгаа

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>118,155,742.84</b>	<b>130,769,097.43</b>
33	АВЛАГА	97,000.00	-
33500	Бусад авлага	97,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	97,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	1,150,000.00
34700	Бусад урьдчилгаа	-	1,150,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	-	1,150,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	1,150,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	118,058,742.84	129,619,097.43
35100	Түүхий эд материал	4,494,574.54	14,590,954.54
35110	Тусгай зориулалттай материал	884,516.54	10,497,217.54
35130	Эм боох материал	3,610,058.00	4,093,737.00
35400	Хангамжийн материал	113,564,168.30	115,028,142.89
35410	Бичиг хэргийн материал	9,138,483.98	6,542,460.00
35420	Аж ахуйн материал	93,141,545.39	87,651,748.15
35440	Түлш, шатах тослох материал	1,316,563.85	-
35450	Барилгын засварын материал	1,914,630.00	595,840.00
35460	Хүнсний материал	6,428,203.68	14,764,083.34
35470	Бусад хангамжийн материал	1,624,741.40	5,474,011.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>2,056,674,168.67</b>	<b>2,183,651,586.61</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,056,674,168.67	2,183,651,586.61
39200	Биет хөрөнгө	2,053,826,168.63	2,179,304,586.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,821,494,460.66	1,821,494,460.66
39202	Хуримтлагдсан элэгдэл- Барилга	-4,327,500.00	-78,876,228.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,458,333.00	227,015,468.00
39204	Хуримтлагдсан элэгдэл-Тээврийн хэрэгсэл	-73,843,749.90	-104,537,598.03
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	558,168,728.57	711,663,231.57
39206	Хуримтлагдсан элэгдэл- Тоног төхөөрөмж	-447,510,464.64	-488,326,775.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	165,236,752.59	168,658,752.59
39208	Хуримтлагдсан элэгдэл- Тавилга	-96,345,762.19	-110,597,148.75
39217	Номын фонд	32,495,370.54	32,810,424.54
39300	Биет бус хөрөнгө	2,848,000.04	4,347,000.04
